

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 дүгээр сарын 12

Дугаар 68

Улаанбаатар хот

Төрийн дээд шагналд

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсгийг үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван нэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Шинжлэх ухаан, эрүүл мэнд, хууль эрх зүй, соёл урлаг, боловсрол, тээвэр, худалдаа үйлчилгээ, аж үйлдвэр, барилгын салбарт олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа хавсралтад дурдсан нэр бүхий иргэдийг төрийн цол хүртээх, одон медалиар шагнуулахаар тодорхойлж Нийслэлийн Засаг даргад уламжилсугай.

2.Төрийн цол хүртээх, одон медалиар шагнуулахаар тодорхойлж буй иргэдийн материалыг Нийслэлийн Засаг даргад хүргүүлэх, тогтоолын хэрэгжилтийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг дүүргийн Засаг дарга (Н.Баярмөнх)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны дарга (Ч.Мэндсайхан)-нд үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАЯР